

5.1. Хэрэглэгчийн үнэлгээ

Ховд аймгийн төрийн алба, үйлчилгээний гүйцэтгэлийн талаар иргэдээс авсан санал асуулгад үнэлэлт дүгнэлт өгсөн байдал

Аймгийн иргэдээс хууль тогтоомж, төр засгийн бодлого шийдвэр, төрийн үйлчилгээ иргэдэд хэрхэн хүрч байгаа, орон нутгийн удирдлагын болон төрийн албан хаагчдын үйл ажиллагааны талаар иргэдийн санал асуулгыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын газрын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг зохион байгуулан явууллаа.

Санал асуулгад аймгийн хэмжээнд 2510 хүнээс санал асуулга авч хууль тогтоомж, төр засгийн бодлого шийдвэр, төрийн үйлчилгээг иргэдэд хэрхэн хүрч байгаа, орон нутгийн удирдлагын үйл ажиллагааны талаар ард иргэдийн санал бодлыг судлаж, дүгнэлт хийлээ.

Санал асуулгын явцад иргэдээс төрийн байгууллагатай холбоотой

-төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай болгож, нэг цэгийн буюу иргэдэд чирэгдэлгүй үйлчлэхэд онцгойлон анхаарах

-явуулах гэж байгаа үйл ажиллагаа, хийх гэж байгаа ажлаа илүү ил тод болгох, асуудлыг шуурхай үнэн шийдвэрлэж, цаг үеийн шинжтэй зарим үйл ажиллагаанд ард иргэдийн хүлээлт бий болгохгүй байх

-Боловсон хүчнийг шилж сонгох, сургаж дадлагажуулах, сонгон шалгаруулахад анхаарлаа хандуулж төрийн нэр хүндийг ард түмний дунд өндөрт өргөж ажиллах

1.Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийн талаарх санал 3.8 оноо буюу төдийлөн хангалттай биш гэж үзсэн байна.

2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх санал асуулгад 4.1 оноо буюу хангалттай гэж үзсэн байна.

3.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээний талаарх асуулгад 4.3 буюу хангалттай гэж үзжээ

4. Аймгийн хэмжээнд иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний талаарх асуулгад 4.7 буюу хангалттай гэсэн үнэлэлт өгчээ.

Эдгээр үнэлгээний дундаж оноо 4.2 буюу хангалттай гэсэн дүгнэлтийг авч байна.

Санал асуулгад оролцсон иргэдээс аймгийн хэмжээнд жижиг дунд үйлдвэрийг дэмжих, олон улсын төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх, зам тээвэр, шуудан холбоог хөгжүүлэх, төрийн алба хаагчдын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, аялал жуулчлалын үйл ажиллагааг өргөжүүлэх, өргөн хэрэглээний барааны үнийг бууруулах, мөнгөний ханшны уналтыг зогсоох зэрэг саналууд ирсэнийг аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон Засаг даргын Тамгын газрын төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх арга хэмжээ авч байна.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС

